



## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 26 өдөр

Дугаар A/354


Улаанбаатар хот

### Гаалийн улсын байцаагчийн Ёс зүйн дүрэм батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Гаалийн тухай хуулийн 271<sup>1</sup> дүгээр зүйлийн 271<sup>1</sup>.1.1, 274.4, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 1.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.“Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.
- 2.“Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар (Б.Хосбаяр), Ёс зүйн дэд хороо (Д.Цэндсүрэн), Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хорооны дарга нарт даалгасугай.
- 3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2009 оны “Дүрэм батлах тухай” 534 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Р.ОТГОНЖАРГАЛ

1439501 2192

Гаалийн ерөнхий газрын даргын 2016  
08.. дугаар сарын 26-ны өдрийн 9/369 угаар  
тушаалын хавсралт

## ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

11161274761

УХГ0207  
6097863

1.1. Энэ дүрмийн зорилт нь гаалийн улсын байцаагч чиг үүргээ хэрэгжүүлэх, нийгмийн харилцаанд оролцохдоо баримтлах зарчим, даган мөрдөх хэм хэмжээг тодорхойлох, түүнийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, ёс зүй, хариуцлагыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх, олон нийтийн итгэлийг хүлээхэд оршино.

1.2. Энэ дүрмээр ёс зүйн хэм хэмжээ, ёс зүйн шаардлага, үйл ажиллагаанд хориглох зүйл, дүрмийн биелэлтэд хяналт тавих, зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.3. Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гаалийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Гаалийн ариун шударга ёсны тухай Дэлхийн гаалийн байгууллагын Арушагийн тунхаглал холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.4. Энэ дүрэм нь гаалийн улсын байцаагчийн эрх авч, тангараг өргөсөн төрийн тусгай албан хаагчид хамаарах бөгөөд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон албаны нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг сахин биелүүлэх үүрэг хүлээнэ.

### Хоёр. Ёс зүйн хэм хэмжээ

2.1. Гаалийн улсын байцаагч үйл ажиллагаандаа Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээ болон дараах зарчмын хүрээнд доорх ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

#### 2.2. Хүнлэг, энэрэнгүй байх:

2.2.1. гаалийн алба, албан хаагчийн нэр төр, алдар хүндийг эрхэмлэх, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх;

2.2.2. гаалийн харилцаанд оролцогч, үйлчлүүлэгч, бусад байгууллага, албан хаагчийн нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх;

2.2.3.гаалийн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээдэд албан тушаалтан төрийн үйлчилгээг үзүүлэхдээ албаны зохих харилцаа үүсгэн зөв боловсон харьцаж, аливаа хүнд суртал, чирэгдэл үүсгэлгүй зохих мэдээлэл, арга зүйн зөвлөгөөг үнэн зөв өгч ажиллах;

2.2.4.гаалийн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээд нь албан тушаалтантай албан үүргийн хувьд харилцахдаа ёс бус үг хэллэг ашиглан гутаан доромжлох, аливаа хэлбэрээр айлган сүрдүүлэх, өөрийн үзэл бодлоо тулгах зэргээр зүй бус авир гаргахгүй байх;

2.2.5.бусадтай ажил хэрэгч, эелдэг харьцаж бусдыг боловсрол мэдлэг, мэргэшлийн ур чадвар, ажлын туршлагаар ялгаварлан гадуурхахгүй эрх тэгш хандах.

### 2.3.Шударга байх:

2.3.1.албаны чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангарагтаа үнэнчээр, мэргэжлийн үүднээс хандаж, олон нийтийн итгэлийг хүлээх;

2.3.2.ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн, бэлэг шан харамж, авлига авах, өгөхгүй байх, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж энэ тухай эрх бүхий албан тушаалтанд тухай бүр нь мэдээлэх;

2.3.3.хувийн болон нийгмийн харилцаанд оролцохдоо нэр төртэй, үнэнч, зарчимч, хүндлэл төрүүлэхүйц байдлыг эрмэлзэх.

### 2.4.Хариуцлагатай байх:

2.4.1.ёс суртахууны хувьд өндөр төлөвшилтэй байж, гаалийн харилцаанд оролцогч, үйлчлүүлэгчийн нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхолд харшлах аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх;

2.4.2.төрийн болон албаны нууц, байгууллагын нууцаас гадна хувь хүний нууц, аливаа мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур бусдад санаатай болон болгоомжгүйгээр задруулахгүй байх;

2.4.3.албаны дүрэмт хувцас, ялгах тэмдэг, албаны үнэмлэх болон бусад техник хэрэгслийг бусдад дамжуулах, хаяж үрэгдүүлэх, хууль бусаар хэрэглэх, албаны нэрийг хувийн ашиг сонирхлоор ашиглах зэрэг үйлдэл гаргахгүй байх;

2.4.4.ажлын байр, олон нийтийн газар болон хамт олон, нийтийг хамруулсан үйл ажиллагаа, баяр ёслолын үеэр ёс зүйгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх;

2.4.5.өөртөө зарчимч шаардлага тавьж, ёс зүйн хэм хэмжээ зөрчих, ашиг сонирхлын зөрчилд өртөх аливаа эрсдэл гаргахаас урьдчилан сэргийлэх;

2.4.6.байгууллагыг төлөөлж гадаад болон дотоод албан томилтоор ажиллах, Олон улсын хурал, сургалт, зөвлөгөөн, семинарт оролцохдоо тухайн улсын соёл, байгууллагын дипломат ёс, соёл, дэг журмыг сахин хүндэтгэлтэй оролцох, албан томилтоос гадуур зохион байгуулж байгаа цайллагын арга хэмжээнд оролцох, бэлэг, шан харамж авахаас татгалзах;

2.4.7.асуудалд нухацтай хандаж, өөрийн шийдвэр, үйл ажиллагааны үр дагаврыг бүрэн хариуцаж, хариуцлага хүлээх.

## 2.5.Манлайлах:

2.5.1.ёс зүйн үлгэр дуурайлал үзүүлж, манлайлагч байх, байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих;

2.5.2.удирдах албан тушаалтан нь албан хаагчийн гаргасан ажил хэрэгч, бүтээлч санал, санаачилгыг дэмжих, урам өгч сайшаах, бодитоор шийдвэрлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх;

2.5.3.удирдлагад байгаа албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавих, гаалийн улсын байцаагчийн албан үүрэгт нь болон байгууллагын хэвийн үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлөхүйц үүрэг, даалгавар өгөхгүй байх.

## 2.6.Хамтаж байх:

2.6.1.харилцан суралцах, мэдлэгээ хуваалцах, туршлага солилцох, шинэ санал, санаачилгыг дэмжих, урам өгөх;

2.6.2.албан ажил, байгууллагаас зохион байгуулж байгаа аливаа үйл ажиллагаанд оролцохдоо цаг баримтлах, идэвх санаачилгатай байж, хамт олон амжилт, алдаа дутагдалд бодитой эерэг шүүмжлэл, санал, дүгнэлт өгөх;

2.6.3.асуудал хэлэлцэх, шүүмжлэл өрнүүлэх, шийдвэрлэхэд нөхцөл байдлыг судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан үнэн зөв үнэлж, дүгнэх, оновчтой арга барилыг сонгох, өөрийн байр сууриа зөв илэрхийлэх, илтэд сөрөг хандлага үзүүлэхгүй байх;

2.6.4.байгууллага дангаар, Ёс зүйн дэд хороо болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулж байгаа олон нийтийг хамарсан сургалт, соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээнд идэвхтэй оролцох.

#### **Гурав.Ёс зүйн шаардлага**

3.1.Гаалийн улсын байцаагч нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан нийтлэг шаардлагаас гадна дараах ёс зүйн шаардлагыг дагаж мөрдөнө;

3.1.1.бусдын зохих ёсоор тавьж байгаа хууль ёсны шаардлага, санал, хүсэлт, нөхөрсөг зөвлөмжийг хүлээн авч сонсон, хүндэтгэлтэй хандах;

3.1.2.гаалийн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн албан тушаалтанд төрийн үйлчилгээг үзүүлэх явцад албан хаагчийг хэл амаар басамжлан доромжлох, улмаар түүнийг аливаа хэлбэрээр айлган сүрдүүлж, биед нь халдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд бусад албан хаагч нарын зүгээс хуулийн хүрээнд уг үйлдлийг таслан зогсоох арга хэмжээг авах;

3.1.3.олон улсын болон үндэсний хэмжээнд олон нийтийг хамруулсан арга хэмжээнд оролцохдоо албаны дүрэмт хувцас өмсөх шаардлага гарсан тохиолдолд өөрийн харьялах удирдлагад мэдэгдэх.

#### **Дөрөв.Үйл ажиллагаанд хориглох зүйл**

4.1.Гаалийн улсын байцаагч нь үйл ажиллагаандаа Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийг баримтлан ажиллахаас гадна дараах зүйлийг хориглоно:

4.1.1.албан тушаалаар олгогдсон эрх хэмжээнд хамаarahгүй асуудалд болон өөрт хуваарилагдсанаас бусад ажил үүрэгт хөндлөнгөөс оролцох, шийдвэр гаргалтад нөлөөлөх, албан тушаалын эрх мэдлээ ашиглан хэл амаар доромжлох, заналхийлэх, доог тохуу хийх, үйл хөдлөлөөр тохуурхах, гадаад үзэмжээр ялгavarлах, басамжлах, нэр төрийг гутаах зэргээр бусад албан хаагчийг ажил үүргээ хэвийн явуулахад саад болж, дарамт, шахалт үзүүлэх, ажлын байранд зохимжгүй маргаан гаргах, зүй бусаар авирлах;

4.1.2.бусдын биед зөвшөөрөлгүй хүрэх, ёс бус үг хэллэг хэрэглэж, сэтгэл санааны байдалд сөргөөр нөлөөлөхгүй, заналхийлэхгүй байх;

4.1.3.гаалийн хяналт хэрэгжүүлэх, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу хяналт хэрэгжүүлэхээс бусад албан ажлаар ажиллах зорилгоор хилийн

боомт, гаалийн хяналтын бүс, гаалийн баталгаат бүсэд (зорчигчийн хувиар татваргүй барааны дэлгүүрт нэвтрэх үл хамаарна) нэвтрэх;

4.1.4.эрх мэдэл, албан тушаалын байдал, албаны нэр хүнд, нөлөөг ашиглах өөртөө болон бусдад эдийн засгийн ашиг хонжоо олгох үйл ажиллагаанд нөлөөлөх, ашиглах;

4.1.5.албан тушаалын болон мэргэжил, мэргэшлийн байдлыг ашиглаж хууль бусаар ашиг, хонжоо олох, бусдад давуу байдал олгох, үйлчлүүлэгчид хувийн чанартай хүсэлт (зээлээр бараа авах, мөнгө зээлэх, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нь хэрэглэх, бусдын мөнгөөр гадаадад зорчих, хямд үнээр бараа худалдан авах, үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэхийг хүсэх зэрэг) шууд буюу шууд бус (үйл хөдлөлөөрөө илэрхийлэх, хоёрдмол утгатай үг, яриа хэрэглэх зэрэг)-аар гаргах, худал амлалт өгөхгүй байх;

4.1.6.шалгаж байгаа болон шалгаж шийдвэрлэсэн гаалийн мэдүүлэг, өргөдөл, гомдол (мэдээлэл) гаргагчтай үүсгэсэн албаны харилцааг ашиглан аливаа хэлбэрээр хувийн ашиг сонирхлын зэрчил үүсгэх харилцаа тогтоох;

4.1.7.гаалийн байгууллагаас явуулж байгаа үйл ажиллагааны бодлого, чиглэл, зохион байгуулахаар төлөвлөсөн санаачилгын талаар иргэд олон нийтэд мэдээлэхдээ урьдчилан дүгнэлт хийхгүй албаны бус хувь хүний байр суурийг илэрхийлэхгүй байх;

4.1.8.байгууллагын нэрийг ашиглан гадаад, дотоод сургалтад удирдах албан тушаалтны шийдвэргүй хамрагдах, байгууллага төлөөлөн илтгэх тавих;

4.1.9.байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагаас явуулж байгаа аливаа үйл ажиллагааг эсэргүүцсэн мэдээ, мэдээлэл тараах, энэ төрлийн арга хэмжээг зохион байгуулж, оролцох;

4.1.10.удирдах албан тушаалтнаас авсан чиглэлээс гадуур мэдээ, мэдээлэл өгөх;

4.1.11.албаны хувцастайгаар албаны бус зорилгоор байгууллагын нэр, лого бүхий үнэмлэх ашиглан мэдээлэл өгөх, хяналт, шалгалт хийх, өөрийн болон бусад албан хаагчийн зураг, бичлэг, мэдээ, мэдээлэл, ярилцлагыг олон нийтийн сүлжээнд зөвшөөрөлгүй нийтлэх, худал мэдээлэл тараах;

4.1.12.үүрэгт ажил, түр хугацаагаар томилогдон гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалыг орлон (хавсрان) гүйцэтгэх, албан томилолтоор ажиллах

явицаа олж мэдсэн хувь хүн, албаны мэдээ, мэдээллийг зохих албан тушаалтны зөвшөөрөлгүй олон нийтэд мэдээлэх, тараах, хувийн зорилгоор ашиглахгүй.

#### **Тав.Дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих**

5.1.Энэ дүрмийн хэрэгжилтэд гаалийн удирдах төв байгууллагын дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгж, харьяа гаалийн газар, хорооны дарга, салбарын эрхлэгч, Ёс зүйн дэд хороо, гаалийн улсын ахлах байцаагч өдөр тутамд хяналт тавина.

5.2.Ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж байгаа нь албан хаагчийг шагнаж, урамшуулах, өөр албан тушаалд дэвшүүлэх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, албан тушаал бууруулах үндэслэл болох бөгөөд ёс зүйн хэм хэмжээний хувьд бусдад үлгэр дуурайлал үзүүлсэн, гаалийн харилцаанд оролцогч, хамт олны талархал хүлээсэн албан хаагчийг “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу шагнаж, урамшуулж болно.

#### **Зургаа.Бусад**

6.1.Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм зөрчсөн эсэхийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан харьяаллын дагуу шалгаж, шийдвэрлэнэ.

6.2.Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой асуудлыг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэнэ.

---оо---